

**“БЭЛЧЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2022.06.29

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (I-IV улирал)	Гүйцэтгэл
Зорилго 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана.						
1	Зорилт: 3.3.3.3. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулж, өрхийн тариаланг нэмэгдүүлэн, хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримлыг тариалуулж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.					
1.1.	Арга хэмжээ 1: Туршилтын талбайг бууц, органик бордоогоор хөрсний чанарыг сайжруулах	Бордсон талбайн хэмжээгээр	8 га	10 га	II-III улиралд	Туршилтын 150 га талбайгаас 2022 оны 05 дугаар сарын эхний 5 хоногт хөрсний үржил шимийн үзүүлэлт, тариалалт хийсэн олон наст ургамлын ургалтын байдлыг харгалзан 10 га талбайг сонгон авч 1 га-д 10 тн нормоор тооцож компост бордоо болон бууцаар бордох ажлыг хийсэн.
1.2.	Арга хэмжээ 2: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг бүх техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цаг урсгал засварыг цаг тухайд нь хийж, байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 хувь	100 хувь	I-IV улиралд	Урсгал засварын төлөвлөгөө боловсруулан, батлуулж, төлөвлөгөөт хугацаанд тракторын турбин болон гидрийн механизмын гэмтлийг оношлон, засварын ажлыг амжилттай гүйцэтгэсэн. Мөн хөрс боловсруулах болон үрлэгээний ажилд ашиглах бүх тоног төхөөрөмжийн урсгал засварын ажлыг гүйцэтгэсэн.
1.3.	Арга хэмжээ 3: Байгууллагын техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан иргэд, аж ахуйн нэгжүүдийн захиалгын дагуу газар тариалангийн үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэх.	Газар тариалангийн үйлчилгээ авсан иргэн аж, ахуйн нэгжийн тоо	4	8	II-IV улиралд	1 аж ахуйн нэгжийн захиалгын дагуу “Газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан газар хагалах, хөрс боловсруулах ажлыг 10 га-д хийж гүйцэтгэсэн.

2.1.	Арга хэмжээ 1: Эрчимжсэн мал аж ахуйн фермийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллах, өдөр тутмын ажлыг графикийн дагуу гүйцэтгэх, малыг эрүүл мэндийн үзлэг болон урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтад байнга хамруулах,	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 хувь	100 хувь	I-IV улиралд	Энэ онд 20 үнээ тугалж, 20 төл хүлээн авсан. Фермийн байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж, гэрээт малын эмчид үзүүлэн, эрүүл мэндийн үзлэг болон вакцинжуулалтад бүрэн хамруулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд нийт 1600 литр сүүг бэлтгэсэн.
2.2.	Арга хэмжээ 2: Нийслэлийн иргэд, малчид, фермерүүдэд зориулж малчдын хоршоо байгуулах, түүний ач холбогдол болон хөдөө аж ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан хүний тоогоор	35	50	II-IV улиралд	Малын удмын сан, НХХААГ, "Нутаг академи" ТББ-тай хамтран "Бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх" сертификаттай сургалтыг байгууллагын 90 үхрийн аж ахуй дээр зохион байгуулсан. Хөдөө орон нутаг болон нийслэлээс тус сургалтанд хамрагдсан 27 хүнд байгууллагын зүгээс нэвтрүүлж байгаа дэвшилтэт техник, технологийн талаар болон малын өтөг бууц, хүнсний био хог хаягдлыг ашиглан компост бордоо хийж бэлчээр, хадлангийн талбайг бордож, хөрсний үржил шимийг сайжруулж байгаа үр дүнг танилцуулж, зөвлөгөө өгсөн. Мөн Фермер Г.Туул тус сургалтанд амжилттай хамрагдан сертификат гардан авсан.
3.1.	Арга хэмжээ 1: 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.	Санхүүгийн мэдээллийг шилэн дансанд байршуулсан тоо	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	I-IV улирал	Шилэн дансанд өссөн дүнгээр нийт 68 мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.
᠑᠘	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд	Үйл ажиллагааны	-	100 %	II-IV	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ногоон хот-Иргэний оролцоо" хаврын мод тарих аяны хүрээнд байгууллагын

айл өрх, ААНБ-ыг идэвхитгэж оролцуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулах	хэрэгжилт, хувь				албан хаагчид 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 хороо, Айдсын ам /7 га/-ны талбайн хуваарьт газраа 24 ш хайлаас мод тариалав. Үйл ажиллагаанд оролцохдоо Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохжилт ногоон байгууламжийн гүйцэтгэл хяналтын хэлтэсээс зөвлөмж авч хамтран ажилласан. Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар модны тарьц суулгац бэлдэх мод үржүүлгийн газар байгуулах ажлын хүрээнд Хужирбуланд 5 га атаршсан талбайг хагалж, хөрс боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв. Фермийн хашаан дахь мод бут ногоон байгууламжийн арчилгаа усалгааны ажлыг тогтмол хийж байна.
Байгууллагын 5 га ногоон талбайд тэжээлийн таримал тариалж ургац хураан авах ажлыг хийж гүйцэтгэх	Хураан авах ургацын хэмжээгээр	21.3 тн	25 тн	II-IV улиралд	Байгууллагын 5 га талбайг хагалж боловсруулан ногоон тэжээл бэлтгэх зорилгоор овъёос тариалав.

ТАЙЛАН ГАРГАСАН:
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ
ОНӨТҮГ-ЫН ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

С. Ариунбаяр Г.ПҮРЭВСҮРЭН